



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

**“Би Монгол хүүхэд” ёс заншлын наадамд  
оролцогчдод дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын дунд зохион байгуулагдах “Би Монгол хүүхэд” ёс заншлын наадамд “Хангай” цогцолбор сургуулийн 10 сурагчийг бэлтгэн оролцуулсугай.

2. Наадмын бэлтгэлд шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээнд шаардагдах 776,000 (Долоон зуун далан зургаан мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Наадамд оролцох сурагчдын бэлтгэлийг сайтар хангуулан зохион байгуулалтын өндөр түвшинд чанар, үр дүнтэй оролцуулахыг “Хангай” цогцолбор сургууль (Э.Соёмбобат)-д, захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 000 дугаар  
захирамжийн хавсралт



“БИ МОНГОЛ ХҮҮХЭД” ЁС ЗАНШЛЫН НААДАМД ОРОЛЦОГЧДЫН  
БЭЛТГЭЛД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

д/д	Төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүр зардал	Нийт зардал
1	Эрэгтэй малгай	ш	5	50,000	250,000
2	Эмэгтэй толгойн гоёл	ш	5	30,000	150,000
3	Атлас	метр	10	12,000	120,000
4	Резин	метр	8	2,000	16,000
5	Эсгий	метр	20	12,000	240,000
	Дүн				776,000